



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 05 өдөр

Дугаар A/178.

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12, 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу харьяа төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтуулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор төсвийн байгууллагын бүтэц орон тоонд дүн шинжилгээ хийж, шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Л.Доржбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга:

Х.Мөнхсаруул (Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

Гишүүд:

М.Цогзолмаа (Төрийн захирагааны удирдлагын хэлтсийн дарга)

Н.Эрдэнэ-Очир (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Г.Энхтайван (Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Г.Самданцоодол (Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга)

С.Хулан (Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга)

Б.Алтантөгс (Эрүүл мэндийн газрын дарга)

Б.Энхмандал (Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

2. Орон нутгийн төсөвт байгууллагуудын бүтэц орон тоонд дүн шинжилгээ хийж бүтэц орон тоог шинэчлэн боловсруулж, батлах ажлыг 2021 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор зохион байгуулан ажиллахыг ажлын хэсэг (Л.Доржбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

483210458